

2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## САЙДЫН ТУШААЛ

### Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.18, 4.1.20 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаалаар батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Ч.Сугармаа)-т, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ /Х.Пүрэвжаргал/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (А.Мөнхбат)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Журам шинэчлэн батлах тухай” Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаал, “Журамд өөрчлөлт оруулах тухай” 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 45 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

**АГУУЛГА**

Нэг. Ерөнхий зүйл .....	3
Хоёр. Зураг төсөл боловсруулах .....	3
Гурав. Зураг төслийг зөвшилцөх .....	5
Дөрөв. Зураг төслийг баталгаажуулах .....	5
Тав. Зураг төслийг магадлан хянах.....	6
Зургаа. Зураг төслийн мэдээллийн нэгдсэн сан.....	10
Долоо. Хариуцлага .....	10

Зам, тээврийн сайдын 2024 оны  
... дугаар тушаалын хавсралт

## **АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД МАГАДЛАЛ ХИЙЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ ЖУРАМ**

### **Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдах авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын барилга, их засварын техник эдийн засгийн үндэслэл боловсруулах судалгааны ажлын тайлан /цаашид “ТЭЗҮ” гэх/, инженерийн нарийвчилсан зураг төсөл (цаашид “зураг төсөл” гэх)-ийг магадлан хянаж, мэргэжлийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр ба өмчийн хэлбэрийг үл харгалзан энэхүү журмын 1.1-д заасан бүх ажлын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах, зөвшилцөх, баталгаажуулах, магадлан хянах, хадгалахтай холбоотой үйл ажиллагаанд энэхүү журмыг болон холбогдох хууль, тогтоомж, норм дүрэм, стандартыг тус тус мөрдөнө.

1.3. Гадаадын зээл, тусlamжийн хөрөнгөөр баригдах авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, тэдгээрийг магадлан хянаж, мэргэжлийн дүгнэлт гаргахад холбогдох олон улсын гэрээ, хууль, тогтоомж, стандарт, норм дүрэм, аргачлал болон энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.4. Авто зам, замын байгууламжийн зураг төслийн баримт бичигт магадлал хийх ажилд Авто замын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.18, 4.1.20, 11 дүгээр зүйлийн 11.1.8, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3 заалтыг тус тус мөрдлөг болгоно.

1.5. Авто замын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8-д заасны дагуу авто замын судалгаа шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага нь авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын зураг төслийг магадлан хянах үйл ажиллагааг зохион байгуулж, шинжээч (цаашид “эксперт” гэх)-ийн мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн “Магадлалын нэгтгэсэн дүгнэлт” (**МНД**) гаргах ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

### **Хоёр. Зураг төсөл боловсруулах**

2.1. Зураг төслийн байгууллага нь инженер-геологи, геодези, археологи, ус зүйн болон бусад шаардлагатай хайгуул, хэмжилт, инженерийн судалгааг, хөрөнгө оруулагч, захиалагч нь санхүүжилтийг хариуцах болон шаардлагатай тохиолдолд байгаль орчны асуудал, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахтай холбоотой зөвшөөрөл гэх мэт асуудлыг хариуцаж гүйцэтгэнэ.

2.2. Авто замын тухай хуулийн 18.1-д заасны дагуу Захиалагч нь авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын ТЭЗҮ боловсруулах судалгааны ажлыг зохион байгуулах ба Хөрөнгө оруулагч, Захиалагч, Гүйцэтгэгч байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу ТЭЗҮ-ийг магадлан хянаж болно.

2.3. Авто замын тухай хуулийн 18.2, 19.1 дэх заалтад заасны дагуу олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг Авто замын асуудал эрхэлсэн төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийн хувьд Аймаг, Нийслэлийн Засаг дарга, бусад авто зам, замын байгууламжийн хувьд тухайн авто замын Захиалагч батална.

2.4. Захиалагч нь зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт зураг төсөл, төсөвт өртийн нэгдсэн тооцоог заавал магадлан хянуулах талаар тодорхой тусгасан байна.

2.5. ТЭЗҮ, зураг төслийг Авто замын тухай хуулийн 33.1-д заасан байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага боловсруулна.

2.6. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын зураг төслийг хоёр үе шаттай боловсруулна. Нэг дэх үе шатны хүрээнд урьдчилсан байдлаар зураг төслийн хувилбаруудаас Захиалагч сонголт хийх ба шаардлагатай гэж үзвэл Зам, тээврийн салбарын Шинжлэх ухаан, технологийн холбогдох дэд зөвлөлөөр хэлэлцүүлж хувилбар сонголтын эцсийн шийдвэр гаргуулна. Хоёр дахь үндсэн үе шатны хүрээнд ажлын даалгаварт заасны дагуу зураг төслийн иж бүрдлийг хангаж, холбогдох тооцоо, судалгаатай холбоотой асуудлын шийдэл хамаарна.

2.7. Зураг төсөл боловсруулахад Авто замын тухай хуулийн 19.2 дахь заалт болон энэ журмыг мөрдлөг болгоно. [Инженерийн судалгааны ажлыг “Авто зам төсөллөх” нормын 3, 4, 5 дугаар хавсралтад заасны дагуу, Эдийн засгийн судалгааны ажлыг “Авто зам төсөллөх” нормын 3 дугаар хавсралтад заасны дагуу хийж гүйцэтгэнэ](#).

2.8. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын барилга, их засварын ажлын техникийн шаардлага (**ТШ**) нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм, дүрэм, стандартад нийцсэн байна. Тухайн хэрэгжиж буй төсөл арга хэмжээ, газар нутгийн нөхцөл байдал, онцлогт тохируулан техникийн шаардлагыг төсөл болгонд тусгайлан боловсруулна.

2.9. Зураг төслийн байгууллага нь төслийн танилцуулга, төсөл хэрэгжүүлэх үндэслэл болон төслийн бүс нутгийн байгаль цаг уурын нөхцөл, байршил, чигийн сонголт, тэдгээрийн хувилбарууд, далан ба хучилт, хиймэл байгууламжийн тооцоо, тооцооны үр дүнгийн тайлбар, замын хөдөлгөөн зохион байгуулалт, аюулгүй байдал, газар олголтын шийдвэр, холбоо, ус хангамж, цахилгаан болон инженерийн шугам сүлжээний техникийн нөхцөл, зураг төсөл боловсруулахтай холбоотой хийсэн уулзалт, хурлын тэмдэглэл, албан тоот, акт, батлагдсан зураг төсөл боловсруулах ажлын даалгавар, Магадлалын нэгтгэсэн дүгнэлт болон холбогдох бусад мэдээллийг багтаасан инженерийн дэлгэрэнгүй тайлан (**ИДТ**)-г боловсруулна.

2.10. Инженерийн дэлгэрэнгүй тайлангийн агуулгын талаарх дэлгэрэнгүй шаардлагыг төслийн онцлогоос хамааруулан зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт тодорхой тусгасан байна.

2.11. Авто зам, замын байгууламж, аэродромын барилга, их засварын ажлын тоо хэмжээг тодорхойлох, төсөвт өртийн нэгдсэн тооцоог (**ТӨНТ**) тооцоходоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм, дүрэм, стандартын дагуу гүйцэтгэнэ.

2.12. Олон улсын гэрээнд тусгайлан зааснаас бусад тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалтаар барих авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын ТЭЗҮ, зураг төслийг эрх бүхий гадаадын хуулийн этгээд боловсруулах нөхцөлд Монгол орны байгаль, цаг уурын нөхцөл, холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, стандартын дагуу уг чиглэлээр тусгай

зөвшөөрөл бүхий дотоодын аж ахуй нэгжтэй хамtran боловсруулах бөгөөд дараах шаардлагыг хангасан байна.

- 2.12.1. Энэхүү журмын 2.5-д заасан байгууллагатай хамtran ажиллах тухай гэрээ байгуулсан байх;
- 2.12.2. Зураг төслийг Монгол Улсын норм, норматив, техникийн баримт бичиг, стандартад нийцүүлэн боловсруулсан байх;
- 2.12.3. Зураг төслийн эх хувь нь Монгол хэл дээр боловсруулсан, Англи хэл дээр хөрвүүлсэн байна.**
- 2.13. Инженер-геологи болон геодезийн хэмжилт, судалгааны ажлын үр дүн, бодит байдлыг зургийн төслийн байгууллага хариуцна.
- 2.14. Зураг төслийн байгууллага нь мэргэжлийн тодорхой шийдэл гаргах шаардлагатай тохиолдолд зураг төсөлд магадлалын дүгнэлт гаргуулахын өмнө Зам, тээврийн салбарын Шинжлэх ухаан, технологийн холбогдох дэд зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, зөвлөмж авч болно.

### **Гурав. Зураг төслийг зөвшилцөх**

- 3.1. Ажлын даалгаварт зураг төслийг зөвшилцөх байгууллагыг тодорхой зааж өгнө.
- 3.2. Зураг төсөлд тухайн замыг дайран өнгөрч байгаа дараах байгууллагатай заавал зөвшилцсөн байна.
  - 3.2.1. Захиалагч;
  - 3.2.2. Орон нутгийн засаг захиргаа;
  - 3.2.3. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээсэн байгууллага;
  - 3.2.4. Газар олголт, төв суурин газрын хот байгуулалт, ерөнхий төлөвлөгөөний асуудал хариуцсан байгууллага;
  - 3.2.5. Дэд бүтцийн шугам сүлжээний ашиглалт, төлөвлөлт хариуцсан байгууллага (шаардлагатай тохиолдолд);
  - 3.2.6. Замын хөдөлгөөн зохион байгуулалтын газар (шаардлагатай тохиолдолд).
- 3.3. Зураг төслийг холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, стандарт, техникийн баримт бичгийг баримтлан зөвшилцж, акт, хурлын тэмдэглэл, холбогдох зөвлөмж, дүгнэлтийг инженерийн дэлгэрэнгүй тайланд тусгаж, хавсаргасан байна.

### **Дөрөв. Зураг төслийг баталгаажуулах**

- 4.1. Зураг төслийн хуудас бүрийг зургийн ерөнхий инженер, гүйцэтгэсэн, шалгасан инженер болон зураг төслийн нүүр болон зохих хуудаст зураг төслийн байгууллагын дарга болон зөвшилцсөн байгууллагуудын холбогдох албан тушаалтан тус тус гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна.
- 4.2. ТЭЗҮ, зураг төслийг эрх бүхий гадаад улсын хуулийн этгээд Монгол Улсын эрх бүхий байгууллагаас олгосон холбогдох тусгай зөвшөөрөл бүхий дотоодын хуулийн этгээдтэй

хамтран боловсруулсан бол хоёр талын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг, тэмдгээр хамтран баталгаажуулсан байна.

4.3. Энэхүү журмын 2.2-т заасны дагуу ТЭЗҮ-ийн судалгааны тайланг магадлан хянасан тохиолдолд аливаа эдийн засгийн болон төсөвт өргтийн тооцоог магадлалын нэгтгэсэн дүгнэлтээр болон тэмдэгээр баталгаажуулахгүй.

#### **Тав. Зураг төслийг магадлан хянах**

5.1. Зураг төслийг магадлан хянуулахад инженер-геологийн тайлан, инженерийн шугам сүлжээний зураг төсөл нь магадлан хянагдаж, баталгаажсан байх ба ТЭЗҮ ирүүлнэ. Захиалагч зураг төслийн иж бүрдэл нь ажлын даалгаварт заасан иж бүрдлийн шаардлагыг хангасан эсэхийг хянана.

5.2. Магадлан хянуулах зураг төсөл нь ажлын даалгавраас хамаарч дараах баримт бичгийн бүрдлийг хангасан байна.

- 5.2.1. Байршил тогтоосон шийдвэр;
- 5.2.2. Зураг төсөл боловсруулахад өгөгдсөн ажлын даалгаврууд (Захиалагч болон Зураг төслийн байгууллагаас гаргасан бүх судалгааны ажлын), биелэлтийн тайлан;
- 5.2.3. Зураг төслийн иж бүрдлийн хангасан талаарх Захиалагчийн тодорхойлолт;
- 5.2.4. Техник-эдийн засгийн үндэслэлийн тайлан (урьдчилсан зураг төсөл);
- 5.2.5. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан, дүгнэлт;
- 5.2.6. Инженер-геологийн тайлан;
- 5.2.7. Инженер-геологийн магадлалын дүгнэлт
- 5.2.8. Инженер-геодезийн хэмжилтийн тайлан;
- 5.2.9. Инженерийн нарийвчилсан зураг төсөл,
- 5.2.10. Ус зүйн судалгааны тайлан;
- 5.2.11. Цахилгаан, гэрэлтүүлгийн зураг төсөл;
- 5.2.12. Холбооны зураг төсөл;
- 5.2.13. Ус хангамж, ариутгах татуургын зураг төсөл;
- 5.2.14. Дулаан хангамжийн зураг төсөл;
- 5.2.15. Техникийн шаардлага;
- 5.2.16. Инженерийн дэлгэрэнгүй тайлан;
- 5.2.17. Техникийн нөхцөл;
- 5.2.18. Холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн акт, хурлын тэмдэглэл, зөвлөмж, дүгнэлт;
- 5.2.19. Төсөвт өргтийн нэгдсэн тооцоо гэх мэт.

5.3. Энэ журмын 1.5-т заасан байгууллага нь зураг төслийг магадлан хянах үйл ажиллагааг дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:

- 5.3.1. Авто зам, замын байгууламж, аэродромын ТЭЗҮ, инженерийн болон шугам сүлжээний нарийвчилсан зураг төсөлт, төсөвт өртгийн нэгдсэн тооцоо, инженер-геологийн судалгааны тайлан, ус зүйн судалгааны тайланг тус тус магадлан хянаж, мэргэжлийн дүгнэлт гаргах.
- 5.3.2. Зураг төслийг магадлан хянах шаардлага хангасан иргэн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, экспертийн эрх олгох, гэрээ байгуулах, дүгнэх, мэргэжлийн дүгнэлт гаргах үйл ажиллагаанд хяналт тавьж, алдаа, зөрчил гаргасан экспертийн эрхийг цуцлах, хариуцлага тооцох арга хэмжээ авах саналыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх.
- 5.3.3. Магадлан хянуулахаар ирүүлсэн хүсэлтийг судлан үзэж, энэ журмын 5.2-т заасан баримт бичгийн бүрдлийг бүрэн хангасан зураг төсөлд хяналтын хуудасны дагуу экспертийг томилох, зураг төслийн байгуулагатай магадлан хянах ажлын зардлыг тусгасан гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих.
- 5.3.4. Зураг төслийн чанарыг дээшлүүлэх болон магадлан хянах үйл ажиллагаа бололовсронгуй болгоход чиглэгдсэн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх;
- 5.3.5. Зураг төслийг магадлан хянах явцад гарсан маргаан болон алдаатай зураг төслийг магадлан хянасан этгээдэд авах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх.
- 5.3.6. Зураг төслийг магадлан хянах экспертийн мэргэжлийн дүгнэлт болон Магадлалын нэгтгэсэн дүгнэлтийн маягт, зураг төслийг баталгаажуулах тэмдгийн загварыг батлах.
- 5.3.7. Зураг төслийн мэдээллийн нэгдсэн цахим сан үүсгэх.
- 5.4. Сүүлийн 2 жилийн хугацаанд магадлан хянагдаж, баталгаажсан зураг, төсвөөр талбайд ажил эхлээгүй буюу барилгын ажлын гүйцэтгэгч нь сонгон шалгараагүй бол тухайн зураг, төсвийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, норм норматив, техникийн баримт бичгийн дагуу Захиалагчийн шийдвэрээр шинэчлэн дахин магадлан хянуулна.
- 5.5. Энэ журмын 5.4-т заасны хүрээнд зураг, төсвийг шинэчлэн бололовсруулсан, мөн Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн жилд зарцуулах хэмжээгээр төсвийг хэсэгчлэн хуваах, түүнийг дахин магадлан хянуулах тохиолдолд гарсан зардлыг төсөвт өртгийн нэгдсэн тооцоонд тусгах бөгөөд бусад тохиолдолд ТЭЗҮ, зураг төслийг бололовсруулах зардлыг тусгахгүй.
- 5.6. Авто зам, замын байгууламж, аэродромын төсөвт өртгийн нэгдсэн тооцоог дараах тохиолдоос бусад тохиолдолд дангаар нь магадлан хянахгүй. Үүнд:
- 5.6.1. Энэ журмын 5.4-д заасны хүрээнд захиалагч нь батлагдсан зургийг шинэчлэх шаардлагагүй гэж үзэж, зөвхөн төсөвт өртгийн нэгдсэн тооцоог шинэчлэх гэрээг зураг төслийн байгууллагатай байгуулсан;
- 5.6.2. Төсөв бodoх нормд өөрчлөлт орсон (Захиалагчийн шийдвэр);
- 5.7. Хийц, технологийн онцлог, төвөгшилтэй шийдэл бүхий авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын зураг төсөлд “экспертийн баг”-ийг томилон ажиллуулж, зураг төслийн ажлын үе шат бүрт хяналт тавих замаар хэсэгчлэн болон үе шаттайгаар магадлан хянах үйл ажиллагааг зохион байгуулж, мэргэжлийн дүгнэлт гаргаж болно.

5.8. Батлагдсан зурагт Захиалагчийн шийдвэрээр өөрчлөлт оруулсан бол зургийн зөвхөн өөрчлөлт орсон хэсгийг магадлан хянах бөгөөд дараах баримт бичгийг үндэслэнэ. Үүнд:

- 5.8.1. Захиалагч байгууллагын зурагт өөрчлөлт оруулах шийдвэр (Үндэслэл, холбогдох баримт бичиг);
  - 5.8.2. Зурагт өөрчлөлт оруулах гэрээ.
- 5.9. Зураг төслийг магадлан хянах зардлын хэмжээ нь тухайн зураг төсөл боловсруулах ажлын гэрээний үнийн дүнгээс хүснэгт 1-д заасан хувиар тооцох бөгөөд үүнээс магадлан хянаж, мэргэжлийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг зохион байгуулах, хэлэлцүүлгийн болон бусад үйл ажиллагаанд зориулан 30%-ийг, магадлан хянах экспертийн цалинд 70%-ийг нь тус тус хуваарилж олгоно. Магадлан хянасан экспертэд олгох хөлсийг зураг төслийн бүрэлдэхүүн хэсэг бүрт ногдох зардлын 80%-г зураг төслийн магадлалд, 20%-г төсөвт өртгийн нэгдсэн тооцооны магадлалд хуваарилна.

Хүснэгт 1

№	ТЭЗҮ, зураг төсөл	Магадлалын зардал тооцох хувь, %
1	Авто зам, замын байгууламж	6
2	Төмөр зам, замын байгууламж	8
3	Аэродром	8

5.10. Ажлын тоо хэмжээг зураг төслийн дагуу орон тооны бус зураг төслийн эксперт магадлан хянана.

5.11. Авто замын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1, 11 дүгээр 11.1.4 дэх заалтын хэрэгжүүлж, “Магадлалын нэгтгэсэн дүгнэлт”-ийг зураг төслийн байгууллагад хүлээлгэн өгөхөд магадлан хянах ажлын зардлын төлбөрийн баримт болон “Авто замын норм нормативын сан”-гийн шимтгэлийн баримтыг үндэслэсэн, Зураг төслийн байгууллага, Захиалагч нь төлсөн байх шаардлагатай.

5.12. Эксперт нь зураг төслийг магадлан хянахдаа дараах шаардлага, нөхцөлүүдийг хангасан эсэхийг хянаж, мэргэжлийн дүгнэлт гаргана.

5.12.1. Авто зам, замын байгууламж, төмөр зам, аэродромын байршил, чигийг тогтоосон шийдвэр, зураг төсөл боловсруулах ажлын даалгавар, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал;

5.12.2. Инженерийн шийдэл, хийц бүтээц нь байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүд, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм норматив, техникийн баримт бичиг, техник ашиглалтын түвшин тогтоо судалгааны ажлын дүгнэлт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу боловсруулсан эсэх;

5.12.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангулсан эсэх;

5.12.4. Хөдөлгөөн зохион байгуулалт, хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг хангулсан эсэх;

5.12.5. Инженерийн шийдлийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаарх дүгнэлттэй эсэх;

- 5.12.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангасан эсэх;
- 5.12.7. Байршил, чиглэл, төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон хувилбарын талаар;
- 5.12.8. Эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, нийгмийн ач холбогдол зэргийг харгалzan хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх;
- 5.12.9. Экспертийн мэргэжлийн дүгнэлтэд хууль тогтоомж, норм нормативын баримт бичгийн шаардлагыг үндэслэн техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашиг, төсөвт өртгийн нэгдсэн тооцоонд өгсөн мэргэжлийн үнэлэлтийг ТЭЗҮ, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгах бөгөөд эцсийн дүгнэлтэд Эксперт нь доорх асуудлыг тодорхойлсон байна. Үүнд:
- магадлан хянаагдсан зургаар барилгын ажлыг хэрэгжүүлэх боломжтой эсэх,
  - магадлан хянаагдсан төсөвт өртгийн нэгдсэн тооцооны эцсийн дүн.
- 5.13. Зураг төслийг магадлан хянах эксперт нь дараах шаардлагыг хангасан байна.
- 5.13.1. Зураг төслийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан, тухайн чиглэлээр Зөвлөх инженер зэрэгтэй байна. Магадлал хийх эрх олгогдсон экспертууд нь эрүүл мэндийн болон бусад хүндэтгэх шалтгааны улмаас магадлан хянах боломжгүй болсон, өөрийн хүсэлтээр магадлан хянахаас татгалзсан тохиолдолд Эксперт нь хугацаагүй мэргэшсэн инженер зэрэгтэй байж болно.
- 5.13.2. Төсөвт өртгийн нэгдсэн тооцоог магадлан хянах эксперт нь 10-аас доошгүй жил төсөвчнөөр ажилласан, Тэргүүлэх эсвэл Хугацаагүй мэргэшсэн төсөвчин зэрэгтэй байна.
- 5.13.3. Эксперт нь ёс зүйн талаар доголдолгүй, ашиг сонирхлын аливаа зөрчилгүй, тухайн зураг төслийг боловсруулсан байгууллагад шууд болон шууд бусаар харьяалагддаггүй, хувьцаа эзэмшдэггүй байна.
- 5.13.4. Эксперт нь “Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.3 дахь заалтын шаардлагын дагуу холбогдох нөхцөлийг бүрдүүлж, 1.5-д заасан байгууллагад хүргүүлсэн байна.
- 5.14. Экспертийг өрсөлдөөний журмаар сонгох ба сонгон шалгаруулах үйл ажиллагаанд Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авна. Экспертээр ажиллах хүсэлтийг энэ журмын 1.5-д заасан байгууллагад хүргүүлнэ.
- 5.15. Эксперт нь зураг төслийг магадлан хянасан бүрдэл хэсэг тус бүрт мэргэжлийн дүгнэлтийг хуанлийн 14 хоногт багтаан гаргаж, шаардлагатай хуудсуудад хувийн тэмдэг болон гарын үсгээр баталгаажуулах ба дүгнэлтээ 1.5-т заасан байгууллагад болон зураг төслийн байгууллагад цахимаар, мөн хэвлэмэл хэлбэрээр тухай бүр хүргүүлж ажиллана.
- 5.16. Тухайн объектын хүчин чадлаас хамааруулан 1.5-д заасан байгууллага нь тохирох тооны эксперт эсвэл экспертийн баг томилно. Магадлан хянах хугацааг үндэслэлгүйгээр сунгахыг хориглоно.

5.17. Зураг төсөлд засвар оруулах шаардлагатай тохиолдолд экспертийн гаргасан мэргэжлийн дүгнэлтийн дагуу Зураг төслийн байгууллага зохих засварыг гүйцэтгэх бөгөөд тайлбарыг гаргаж, экспертэд дахин хянуулснаар экспертийн хувийн тэмдэг болон гарын үсгээр баталгаажуулан 1.5-т заасан байгууллагад хүлээлгэн өгнө.

5.18. Экспертийн баталгаажуулсан мэргэжлийн эцсийн дүгнэлтийг хянаж, хүлээн авснаас хойш авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага нь ажлын 7 хоногт багтаан Магадлалын нэгтгэсэн дүгнэлтийг гаргана.

5.19. “Магадлалын нэгтгэсэн дүгнэлт” нь авто зам, замын байгууламж, төмөр зам, аэроромын төлөвлөлт, инженерийн шийдлүүдэд өгөх мэргэжлийн үнэлгээ байх бөгөөд экспертийн мэргэжлийн дүгнэлтийн хамт хүчин төгөлдөр байна.

5.20. ТЭЗҮ, зураг төсөл, төсөвт өртгийн нэгдсэн тооцоо болон Магадлалын нэгтгэсэн дүгнэлтийг тус тус гарын үсэг, тэмдгээр баталгаажуулсан байна.

5.21. Хот, суурин газрын авто зам, замын байгууламжийн зураг төсөлд ус зайлцуулах байгууламжийг холбогдох стандарт, норм норматив, техникийн баримт бичгийн дагуу төсөллөсөн байна.

### **Зургаа. Зураг төслийн мэдээллийн нэгдсэн сан**

6.1. Магадлан хянагдаж, батлагдсан зургийг болон Магадлалын нэгтгэсэн дүгнэлтийг тус бүр 2 хувь үйлдэж, магадлалын тэмдэгээр баталгаажуулах бөгөөд энэ журмын 1.5-д заасан байгууллага 1 эх хувийг Монгол Улсын Архивын тухай хууль болон бусад холбогдох журмын дагуу хадгална.

6.2. Зураг төслийн байгууллага нь магадлан хянагдаж, батлагдсан зураг, төсвийг [\\*pdf](#), [\\*dwg](#), [\\*kmz](#), [\\*shp](#) болон [\\*res](#) өргөтгөлтэйгөөр энэ журмын 1.5-д заасан байгууллагад батлагдсан өдрөөс хойш хуанлийн 3 хоногийн дотор хүлээлгэн өгнө.

6.3. Энэ журмын 1.5-д заасан байгууллага нь магадлан батлагдсан зураг төслийг холбогдох материалын хамт зураг төслийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэн оруулж, мэдээллийг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал тутам жагсаалтаар хүргүүлнэ.

### **Долоо. Хариуцлага**

7.1. Авто замын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх заалтад заасны дагуу зураг төслийн алдааг зураг төсөл боловсруулсан байгууллага буюу зохиогч хариуцах ба 19.5 дахь заалтад заасны дагуу зураг төслийн техникийн шийдэл болон төсөвт өртгийн нэгдсэн тооцооны талаар гаргасан мэргэжлийн дүгнэлтийн алдааг магадлан хянасан эксперт хариуцна.

7.2. Зураг төслийг магадлан хянах үйл ажиллагааг зохион байгуулахад гарсан болон магадлалын ерөнхий нэгтгэлийн алдааг энэхүү журмын 1.5-т заасан байгууллага хүлээнэ.

7.3. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр баригдах болон Хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийн зураг, төсвийг өөрчлөх, шинэчлэх тохиолдолд Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас холбогдох шийдвэрийг гаргуулсан байна.

7.4. Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдах авто зам, замын байгууламж, төмөр зам, аэроромын инженерийн нарийвчилсан зургийг боловсруулсан байгууллага нь Монгол улсын геодезийн сүлжээний цэгтэй холбогдсон объектын байршил, чигийн /трас/ дагууд байгаа хэвтээ хяналтын цэгийн байршил, зай хэмжээ, өндөржилтийг барилгын ажлыг эхлүүлэх шатанд Захиалагч, Зөвлөх, Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөлд заавал хүлээнцнэ.

7.5. Барилгын ажлын явцад зураг төслөөс шалтгаалсан алдаа гарсан, алдааг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналт шалгалтын эрх бүхий этгээд акт тогтоосон тохиолдолд гэрээ болон холбогдох хууль журамд заасны дагуу зураг төслийг боловсруулсан байгууллагаар гарсан хохирлыг барагдуулах, тусгай зөвшөөрлийг цуцалж, хар жагсаалтад оруулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

7.6. Эксперт нь энэхүү журам ба гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, норматив, стандартыг зөрчсөн, алдаатай дүгнэлт гаргасан, зураг төслийн техникийн буруу шийдлийг засаж, залруулаагүй, мэргэжлийн болон ёс зүйн зөрчил удаа дараа гаргасан тохиолдолд экспертийн эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

7.7. Эксперт болон энэ журмын 1.5-т заасан байгууллагын гаргасан Магадлалын нэгтгэсэн дүгнэлт нь Авто замын тухай хууль тогтоомж, стандарт, норм, нормативыг зөрчсөн авто зам, замын байгууламжийн барилгын ажлын явцад болон ашиглалтын хэвийн нөхцөлийг алдагдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйлд заасны дагуу шийтгэл ногдуулна.

-оОо-